



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны IV сар)

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ IV САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН 3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 3

- 1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил 3
 - 1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ 3
 - 1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ 4
 - 1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ 5
 - 1.1.4. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 5
- 1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр) 6
 - 1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо 6
 - 1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт 7
 - 1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт 7

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 9

- 2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ 9
- 2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил 9
- 2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ 10
- 2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 11

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БУСАД АЖЛУУД 12

- 3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ 12
- 3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ 14
- 3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил 14

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ IV САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны IV сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.04.01 - 2026.04.30)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 2026 оны 04 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **319** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 9,293,094 вон, нутаг буцах зардал: 1,049,294 вон, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү: 6,338,310 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 15,549,012 вон зэрэг хэлбэрээр нийт **32,229,709** воныг Монгол Улсын **14** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ

- Иргэн О.Б (Е-9) нь хугацаанаасаа өмнө нутаг буцаад эргэж ирэх боломжгүй нөхцөл үүссэн тул ажил олгогчтой холбогдон ажлаас гарах мэдэгдлийг хийлгэж, 13 дахь сарын цалин 7,207,440 вон, нутаг буцах зардал 524,540 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан. Мөн тухайн иргэний

үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүүг тооцоолон, ажил олгогчоос нэхэмжилж 6,338,308 воныг дансанд нь олгуулав.

- Иргэн Х.Л (Е-7) нь визний ангиллаа сольсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж нутаг буцах зардал 524,750 вон, 13 дахь сарын цалин 2,085,650 воныг олгуулав.
- Иргэн Б.С-ийн (Е-9) үйлдвэрлэлийн осолд бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч эмчлүүлж буй 메트로정형외과 эмнэлэгт бүртгэлийг хийлгэснээр эмчилгээний зардал, цалин хөлсний 70 хувийг авч байна.
- Иргэн Ц.Т (Е-9) нь нутаг буцах болсон тул 13 дахь сарын цалинг нэхэмжилж, холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээв.
- Иргэн Б.Б (Е-9) агсны ар гэрт олгуулах гэнэтийн ослын даатгалын материалыг бүрдүүлэх явцад нэмэлтээр шаардсан баримт бичгийн бүрдүүлэлтэд туслалцаа үзүүлэв.
- Иргэн Н.М-ийн (Е-9) олгогдоогүй хойшлогдсон цалингийн өргөдлийг хүлээж авч, холбогдох баримтыг бүрдүүлж байна.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ

- Иргэн Р.А (визгүй), Б.Б (визгүй), Г.Б (визгүй), С.А (визгүй), Ш.М (визгүй) нарын 5 хүний цалин хөлс нийт 10,240,000 воныг нэхэмжилж Хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан иргэний шүүхэд нэхэмжлэл гарган шүүхийн шийдвэр гаргуулсан. Хөдөлмөр халамжийн хэлтэст төрөөс олгох нөхөн төлбөр олгох хүсэлтийг 2026.03.04-ний өдөр илгээж 2026.03.31-ний өдөр нийт 9,960,000 воныг олгуулсан.
- Иргэн Ж.Б-гийн (визгүй) барилгын ажил хийгээд авч чадаагүй цалин 2,000,000 воныг нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Ш.Б-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг Сөүл баруун бүсийн Хөдөлмөрийн хэлтэст гарган 2,600,000 вон олгуулсан.
- Иргэн Ч.О-гийн (визгүй) буудалд ажилласан нэг өдрийн олгогдоогүй цалин болох 89,000 воныг ажил олгогчоос нь нэхэмжилж 2026.03.24-ний өдөр олгуулсан.
- Иргэн М.Б-гийн (визгүй) олгогдоогүй цалингийн өргөдлийг шийдвэрлэхээр захиралтай нь холбогдож, талууд харилцан тохиролцсоноор өргөдөл гаргагч нь мөнгөн дүнд дүйцүүлэн барилгын нураалтын багаж авч, өргөдлөө хаалгасан.
- Иргэн О.Б-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс 4,000,000 вон олгуулах хүсэлтийг 2026.03.18-ны өдөр хүлээн авч, Хөдөлмөрийн хэлтэс (목포고용노동지청)-т өргөдлийг шилжүүлсэн.
- Иргэн Г.Д нарын 5 хүний (визгүй, G-1) олгогдоогүй цалин хөлс өргөдлийн бүрдүүлбэрийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Иргэн С.О-гийн (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртөж ажил олгогчоос ажилгүй байсан үеийн цалин хөлсийг олгуулах хүсэлтийг хүлээн авч 2026.04.30-ны дотор цалин хөлсний 70 хувиар олгохоор тохиролцсон.

- Иргэн Э.Ч-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс 300,000 вон олгуулах хүсэлтийг хүлээн авч Хөдөлмөрийн хэлтэст өргөдлийг шилжүүлэхээр ажиллаж байна.
- Иргэн Д.Б (визгүй) нарын 18 хүний олгогдоогүй цалин хөлс 25,814,500 вон олгуулах хүсэлтийг хүлээн авч Хөдөлмөрийн хэлтэс (서울강남고용노동지청)-т өргөдлийг гаргасан.
- Иргэн Ц.Т (визгүй) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байхдаа төлсөн нутаг буцах зардлыг Аж үйлдвэр хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас (서울남부지사) нэхэмжилж холбогдох баримтыг илгээсэн.
- Иргэн Э.С (визгүй), Ц.У (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд гаргаж, баталгааны хуудсыг өргөдөл гаргагчид илгээв.
- Иргэн Ц.Х-гийн (G-1) 13 дахь сарын цалингийн асуудлаар гаргасан өргөдлийг Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлсэн.
- Иргэн Б.Б (визгүй), Х.Б (визгүй) нарын олгогдоогүй цалинг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэс (익산고용노동지청)-т 2026.04.17 ний өдөр өргөдөл гаргасан.
- Иргэн Б.Г-гийн (визгүй) “.....” зочид буудалд ажилласан 1 сарын цалингаа авч чадаагүй тухай өргөдлийг хүлээн авч, баримтыг бүрдүүлэн Сөүл хотын Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд хүлээлгэн өгсөн.
- Иргэн М.Б (визгүй) нураалтын ажил, Б.М (визгүй) тавилгын үйлдвэр, Д.А (визгүй) цонхны үйлдвэр зэрэг газруудад ажиллаад авч чадаагүй цалингийн өргөдлүүдийг хүлээн авч, харьяа Хөдөлмөрийн хэлтэст өргөдлийг хүргүүлэв.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ

“Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын нэгдсэн холбоо” ТББ болон Сөүл хотын “Seoul jump medical center”-тэй хамтран нийгмийн хамгааллын чиглэлээр зохион байгуулж буй эрүүл мэндийн үйл ажиллагааны хүрээнд иргэдэд чиглэсэн “Солонгос улсын эрүүл мэндийн үйлчилгээний талаар танд сонирхож буй зүйлс” судалгааны асуулга (форм)-ыг боловсруулан цахимд 2026.04.09-ний өдөр байршуулсан.

Монгол хэл бичгийн сургалтыг төвийн байранд Ням гараг бүр зохион байгуулж байна.

1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 8 иргэнийг, E-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 8 иргэнийг шинээр бүртгэсэн.
- E-7-4 визний асуудлаар нийт 50 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах,

ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

- Иргэн Х.Б-г хэлний шалгалтад (KIIP 사전평가) бүртгүүлсэн, Ц.Э, А.М нарын хүсэлтээр socianet, kiipstest сайтуудад шинээр бүртгэл үүсгэж, хэлний шалгалтад (KIIP 사전평가) бүртгүүлсэн. Г.Б-гийн визийг Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байна. Гишүүдийн тоо 1002. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд дагалдан визний журамд өөрчлөлт орсон тухай, ажиллах эрхтэй визний тухай, солонгос хэлний ажилд хэрэгтэй үг хэллэгүүд зэрэг 16 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1) Нутаг буцах зардал	2	1,049,290
	2) Цалин, илүү цагийн хөлс		
	3) Самсунгийн 13 дахь сарын цалин	2	9,293,090
	4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	1	6,338,308
	5) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6) Гэнэтийн ослын даатгал		
	7) Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	2	2,089,000
	10) 13 дахь сарын цалин		
	11) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	7	13,460,000
	14) 13 дахь сарын цалин		
	15) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн		14	32,229,688

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
83	30	19	53	–	11

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээ	Тоо
1) Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	22
2) Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	18
3) Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлүүлэх	13
4) Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	29
5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	4
6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	7
7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	1
8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх	6
9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	2
10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга	64
11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх	12
12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх	1
13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа	2

үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх		
14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах		5
15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих		53
16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх		12
17) Бусад мэдээлэл, зөвлөгөө		39
18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх		16
Хүргэсэн үйлчилгээний тоо	Утсаар	213
	Цахимаар	78
	Танхимаар	29
	Нийт	319

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлан хамарсан хугацаа 2026.04.01 - 2026.04.30)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 29 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 34 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 28 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 62 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 42 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 34 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 8 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 18 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 60 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил

Тайлант хугацаанд тус тасаг 284,754,272.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 62 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 120,562,236.27 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 04 дүгээр сард нийт 76 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 63,957,734.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 49 даатгуулагчийн 48,546,800.00 төгрөг, сайн дурын даатгалын 27 даатгуулагчийн 17,410,934.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг биечлэн 63, утсаар 220, цахим чатботоор 23, нийт 306 иргэн, даатгуулагчид үйлчилж, 1 удаа “live” буюу шууд цахимаар иргэдтэй харилцсан.
- 2) БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 1 ээлжийн 2 иргэний 4,827,180.00 вон буюу 11,440,416.6 төгрөгийг нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.
- 3) БНСУ-ын Инчеон хот дахь сургалтын төвд (2026.04.22) Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй 23 иргэнд Нийгмийн даатгалын тухай ойлголт, өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, тус улсын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж, Солонгос улсын Үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох тухай, Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах тухай сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- 4) “Хариуцлагатай амьдарцгаая” аяны хүрээнд тус төв нь БНСУ дахь Монгол Улсын Элчин сайдын яамтай хамтран оюутан, залууст зориулсан “Гадаад оронд хэрхэн хурдан дасан зохицох вэ” сэдэвт сэтгэлзүйн зөвлөгөө, сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тодруулбал, 2026.04.28-ны өдөр Намсүүл их сургуулийн 80, 2026.04.29-ний өдөр Сөүлийн үндэсний их сургуулийн 68, 2026.04.30-ны өдөр Жунан их сургуулийн 150, 2026.05.20-ны өдөр Ёнсэй их сургуулийн 28, 2026.05.21-ний өдөр Корей их сургуулийн 15 оюутан, залуус сургалтад хамрагдав. Сургалтын үеэр гадаад оронд суралцаж, амьдарч буй оюутан, залууст түгээмэл тулгардаг соёлын ялгаа, хэлний бэрхшээл, ганцаардал, стресс, сэтгэл түгшилт зэрэг сэтгэлзүйн сорилтуудыг хэрхэн даван туулах талаар бодит жишээ, практик зөвлөмжийг хүргэж, шинэ орчинд дасан зохицох ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл өгч ажиллалаа. Оюутан залууст нийгмийн даатгалын тухай ойлголт, тэтгэмжийн даатгалын ач холбогдол, Сайн дурын даатгалд хэрхэн хамрагдах, гэрээ хэрхэн байгуулах талаар мөн мэдээлэл зөвлөгөө өгөв.
- 5) БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Монгол Тауны гадна талбайд зохион байгуулж тус өдөрлөгөөр Нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгалд хэрхэн хамрагдах тухай зөвлөгөөг 26 иргэнд өгч, 216 хүнд хэвлэмэл танилцуулга, материал хүргэсэн (2026.04.24). Энэ удаад БНСУ-ын хуулийн фермийн мэргэжлийн өмгөөлөгчтэй хамтран хуулийн зөвлөгөө, мэдээллийг үнэ төлбөргүй хүргэснээрээ онцлогтой байв. Тус арга хэмжээг сар бүрийн 4 дэх долоо хоногийн Баасан гариг бүр зохион байгуулж ажиллана.

- 6) Тэжон хотын Гадаад иргэдийг дэмжих төвийн байранд (2026.04.26) Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны Консулын хэлтсээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд нэгдэн Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар болон сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлыг танилцуулж, 19 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч 45 хэвлэмэл материал хүргэж, 3 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан.
- 7) Тэгү хот болон Чонан хотод (2026.04.25) Пусан дахь Консулын газар, Сөүл дэхь Төрийн банкны төлөөлөгчийн газар, Кимсон хуулийн фирмийн Гадаадын иргэд ба цагаачлалын төв зэрэг байгууллагуудтай хамтран явуулын үйлчилгээ үзүүлж тус бүс нутагт түүний ойр орчмын хотуудад оршин суугаа иргэдэд мөн Арвай зоогийн газарт очиж Нийгмийн даатгалын тухай ойлголт, мэдээлэл зөвлөгөөг 52 иргэнд өгч ажилласан.
- 8) БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголт хэр зэрэг байгааг тодорхойлох зорилгоор 50 иргэнээс судалгаа авсан.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ		Тоо	Өссөн дүнгээр
1. Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	31	166
	Сайн дурын даатгал	42	212
2. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	Шинээр	28	156
	Дахин	0	14
	Хугацаа сунгасан	34	118
3. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	Шинээр	18	85
	Дахин	8	20
	Хугацаа сунгасан	34	122
4. Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	117,101,700.00	441,565,300.00
	Сайн дурын даатгал	167,652,572.00	681,826,938.00
	Нийт	284,754,272.00 62.0%	1,123,392,238.00 63.7%
5. Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	48,546,800.00	147,465,828.00
	Сайн дур	17,410,934.00	71,057,185.00
6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	11,440,416.60	47,691,516.60
	Олгосон	0	0
	Буцаан олголт авсан хүний тоо	0	0
7. Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	220	1,363
	Цахимаар	23	122
	Танхимаар	63	209

3. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БУСАД АЖЛУУД

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 26, youtube сувагт 3, байгууллагын seoulcenter.mlsp.gov.mn цахим хуудсанд 25 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар иргэд нийт 156,893 удаа хандсан байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 23 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг (2026.04.10) цахимаар, ирсний дараах сургалтыг (2026.04.16) 21 иргэнийг хамруулан Ёжү сургалтын төвд (2026.04.22), 2 иргэнийг хамруулан Инчоны сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих тухай
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- БНСУ-ын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйлс
- Сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний тухай
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээний шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Консулын хэлтэстэй хамтран Гангвон аймгийн Чүнчон хотод (2026.04.04) явуулын үйлчилгээ зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэн, иргэдэд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө өгсөн.

Тэжон хотын Гадаад иргэдийг дэмжих төвийн байранд (2026.04.26) явуулын үйлчилгээ үзүүлж, 25 иргэнд төвийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг танилцуулан, 8 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, хөдөлмөрийн харилцааны талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинарт “Төрийн захиргааны албан хаагчдын чадамжийн оношилгоо, судалгааны дүн”, “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын танилцуулга”, “Монгол Улсын Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын системийн тухай” зэрэг сэдвээр 3 удаагийн цахим сургалтад төвийн нийт албан хаагчдыг хамруулсан.

Зураг 1. Явуулын үйлчилгээний үеэр



3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Тайлант хугацаанд 12 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл сэтгэл гутралын асуудалтай 2, сэтгэл түгшилттэй 3, гэр бүлийн асуудалтай 1, үл ялих байдал (бодол, үйлдэл) 1, мэдрэл сульдал 1, бусад шалтгаантай 4 иргэн байна.

2026 оны 4 дүгээр сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 20 иргэнд нойргүйдэл илрүүлэх сорил, сэтгэл гутралын болон сэтгэл түгшилтийн сорил хийж, дүгнэлт гаргав. Үүнд:

- Нойргүйдэл илэрсэн 12 иргэн (20-29 нас), 2 иргэн (30-39 нас)
- Сэтгэл түгшилтийн завсрын байдалтай 6 иргэн (20-29 нас) байна.

СЭМҮТ-ийн сэтгэл засалч, сэтгэцийн эмч Н.Нацагсүрэнтэй хамтран Ажлын байрны стрессээс сэргийлэх, багаар хамтран ажиллах, хувь хүний сэтгэл зүйн онцлог сэдвээр танхимын сургалт (2026.04.06) зохион байгуулж, төвийн албан хаагчдыг хамруулав.

СЭМҮТ-ийн сэтгэл засалч, сэтгэцийн эмч Г.Гантулгатай хамтран "Эрчүүдээ, дотроо хадгалах биш ярилцацгаая" сэдвээр цахим сургалт (2026.04.05) зохион байгуулсан. Сургалтаар эрчүүдэд түгээмэл тохиолддог сэтгэлзүйн асуудал болон ямар шинж тэмдгээр илэрдэг, түүнийг хэрхэн даван туулж шийдвэрлэх талаар ярилцсан ба нийт 22 иргэн хамрагдав.

3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил

Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг тус тус шинэчилсэн.

2025 онд тогтвортой нөхцөлөөр ирсэн 68 хөдөлмөрийн гэрээт ажилчны ажил олгогчтой холбогдож, ажлын байраар хангаж байгаад талархал илэрхийлэн санал бодлыг нь сонссон. Тэдгээр иргэдийн хувийн холбоо барих дугаарыг олох зорилгоор Нийгмийн даатгалын тасгийн БНСУ-д гэрээгээр ажиллагсдын шимтгэлийн програмаас нэг бүрчлэн шүүж, ажил олгогчоос тодруулсан. Үүний үр дүнд 18 иргэнтэй холбогдож нөхцөл байдлыг нь тодруулан, хууль зүйн зөвлөгөө өгч, Е-7-4 визний талаар мэдээлэл хүргэн мэдээллийн санг шинэчлэв.

2025 оны 1-6 дугаар сард ирсэн хөдөлмөрийн гэрээт ажилчдын мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, солонгос дугаартай 125 гэрээт иргэнтэй эргэх холбоо үүсгэн мэдээллийн санг баяжуулсан.

Албан хаагчид Монгол таунд хуваарийн дагуу ээлжээр ажиллаж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Төвийн танилцуулга, тараах материал 4000 ширхэг, Сайн дурын нийгмийн даатгалын тараах материал 4000 ширхгийг тус тус шинээр хэвлүүлэв.

Тус улсад үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын төрийн болон төрийн өмчит байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон, үр өгөөжтэй өнгөрүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "ЭРҮҮЛ МЭНД-ЭВ НЭГДЭЛ 2026" спорт өдөрлөгийг зохион байгуулав (2026.04.11).

Төвийн албан хаагчдыг хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны талаар холбогдох сургалтад хамруулахаар БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг

эрхлэх газрын Гадаад ажиллах хүчний бодлого төлөвлөлтийн хэлтэст албан бичиг илгээсэн (2026.04.16).

БНСУ-ын Дэду хуулийн фирмтэй уулзалт зохион байгуулж хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар шийдвэрлэв (2026.04.09). Тус байгууллагын өмгөөлөгчид Монгол иргэдэд үнэгүй хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, төвийн чатбот системд хууль зүйн цэс нэмэхэд хамтран ажиллахаар төлөвлөв.

БНСУ-ын “Hanpass” олон улсын мөнгөн шилжүүлэг, дижитал банкны үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай уулзалт зохион байгуулж, “Стрессийг эергээр даван туулах нь” сэдэвт сэтгэлзүйн зөвлөгөө бүхий 500 ширхэг тараах материалыг хэвлүүлэн, хүлээн авсан.

Сөүл хотын Жүнгү дүүргийн цагдаагийн хэлтсийн Олон нийтийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн тасгийн Гадаад иргэд хариуцсан ажилтан Ким Ён Хвантай уулзалт зохион байгуулсан (2026.04.06). Уулзалтаар Монгол Улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар санал солилцсон бөгөөд цаашид идэвхтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

- - - oOo - - -